

## БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХ

Нөөц компани нь анх ТУАКомбинатын харъяа Хоёрдогч түүхий ~~контор~~ контор" нэртэйгээр 1989 оны 4-р сард байгуулагдан үйл ажиллагаагаа эхэлэн 1991 оны 5-р сарын 18 ны өдрийн харъяанд шилжиж БНМАУ-ын Аж ахуйн нэгжийн хуулийн дагуу тус контор төрийн өмчид ажиллах "Нөөц компани УУГ" болон зохион байгуулагдан 10 дахь жилээ ажиллаж байна. Тус конторыг анх байгуулахад даргаар нь Ж.Дэчинцогзол, Нягтлан бодогчоор Л.Мөнхөө, механикаар Н.Баярсайхан төвлөрсөн гурван цэгийн даргаар М.Сосоржав, М.Буянтогтож, Ц.Лугарсүрэн, няраваар Б.Очиржав нийт 54 ажилчидтайгжар үйл ажиллагаагаа явуулан тухайн үед хоёрдогч түүхий эд ялган зэс гууль 9,0 тонн хөнгөн цагаан 9,9 тонн, хөнгөн цагааны хайлж 3,8 тонныг хөвдөж Золбин нохой 6100 ширхэгийг агнаж 931,9 мян/м<sup>3</sup> хог хаягдал гарж устгах 3,7 сая төгрөгийн ажил үйлчилгээ хийж ний байсан байна.

Хогийн цэгүүдэд армун цэвэр сахиулам, хотын орчинд хур хог үүсгэх явдлыг багасган зорилгоор тээвэрлэсэн хаягдлаа цэгт буулгасан жолооч нарт урамшил олгох эрх зүйн болон хөрөнгийн эх үүсвэрийн талмар холбогдох тооцоо судалгаа хийж дээд газраас зөвшөөрөл авч Улаанбаатар хотын АХ-ын ГЗ-ны хуралд оруулж 158,253-р тогтоол гаргуулж байжээ.

1998 оноос хог хаягдлын цэгт хоёрдогч түүхий эд очих нь эрс багассан нь ялгагчаар хүн ажиллах шаардлагагүй болсон тул нийт ажиллагсадаа 29 болговон.

1989-1997 оны хооронд байгууллагынхаа материаллаг баазыг бэхжүүлж бүтэц зохион байгуулалтын хувьд

1. Захиргаа аж ахуй
2. Дарь-эх, Улаанчулуут, Морингийн хог хаягдлын цэгүүд
3. Машин механизмын хэсэг
4. Ижиг үйлвэрийн хэсэг
5. Анчдын хэсэг
6. Мушаан цех

2

нэгжүүдтэй компаний ашиг хуримтлалыг арившуулж 33073979 төгрөгийн дүрмийн сантай 12225202 төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй 4930437 төгрөгийн ашигтай болсон байлаа. Нийслэлийн захирагчийн 1997 оны А/185 тоот захирамжаа Нөөц компанийг татан буулгаж Тохижилт компанитай нийлүүлж нэг жил ажилаад 1998 оны Хотын захирагчийн А/168 тоот захирамжаар нэгдсэн компани татан буугдаж А/180 тоот захирамжаар "Нөөц компанийг дахин байгуулсан билээ. Байгууллагын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөр

1989-1995 онд захирлаар Ж.Дэчинцогзол  
1996 оны 5 сараас 1997.6сар хүртэл Д.Даяндорж  
1997.6-1997-9 хүртэл Ж.Жигжидсүрэн  
1998.8-1999-5 хүртэл Д.Пирэвсүрэн  
1999.6 сараас захирлаар Д.Наран ажиллаж байна.

Нягтлан бодогчоор Б.Цэвээн, механикаар Н.Баярсайхан нар тасралтгүй ажиллаж байгаа.

Одоо тус компани нь хогоо тээвэрлүүлэн цэгт хүргэдэг 2000 шахуу аж ахуйн нэгж байгууллагатай үйл ажиллагаагаараа холбоотой ажиллаж байна.

#### Архивын түүх

Тус компаний архивын бичиг баримтыг 2000 онд анх цэгцэлж одоо 48 хадгаламжийн нэгжтэй болоод байна.

Архивын хадгаламжийн нэгжийн 18 нь захиргаанаас 30 нь санхүүгийн баримтаас бүрддэг.